

**Сайхан-Овоо суманд 2021
онд улсын төсөв, аймаг
болон сумын ОНХС-аар
хэрэгжиж буй хөрөнгө
оруулалтууд**



Улсын төсвийн хөрөнгө оруулалтууд

ХҮНД ДААЦЫН ТӨМӨР БЕТОН ГҮҮР

Гүйцэтгэгч: “Зам, замын байгууламж” ХХК
Зураг төсөл зохиогч байгууллага: “ТГД” ХХК
Хөрөнгө оруулалтын эх үүсвэр, төсөвт өртөг:
Улсын төсөв, 1,500,000,000 төгрөг
Гүүрний урт:54,8 метр
Гүүрний даац:50 тн
Гүйцэтгэл:100%







1. Сайхан-Овоо сумын 320-н сурагчтай спорт зал бүхий сургуулийн барилга

- Гүйцэтгэгч: “ТЭД КОНСТРАКШН” ХХК
Зураг төсөл зохиогч байгууллага: "ТГД" ХХК
Хөрөнгө оруулалтын эх үүсвэр, төсөвт өртөг:
Улсын төсөв, 3,058,888,888 төгрөг
Ажлын явц: 44%
- Ашиглалтанд орох хугацаа: 2022 он
2021 оны 11 сарын 01-ний өдрийн байдлаар барилгын угсралтын ажил 44% хувьтай, А блокны бетон цутгалтын ажил болон Б блокны арматурчлал хийгдэж цутгалт хийгдсэн байна.

Эскиз зураг




2021 оны гүйцэтгэл 44%



2. САЙХАН-ОВОО СУМЫН ТӨВИЙН УСАН ХАНГАМЖ АРИУТГАХ ТАТУУРГЫН ШУГАМ СҮЛЖЭЭ, ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖ

- Гүйцэтгэгч: “Эхлэл шинэчлэл прожект” ХХК
- Зураг төсөл зохиогч байгууллага: "Кингсий инженер энд констракшн" ХХК
- Хөрөнгө оруулалтын эх үүсвэр, төсөвт өртөг: Улсын төсөв, 1,814,398,754 төгрөг
- Ажлын явц: 85%
- 2021 оны 11 сарын 14-ний өдрийн байдлаар даралтад цамхагийн барилга баригдаж дууссан. Ус түгээх байр, шугам сүлжээний ажил бүрэн хийгдэж төсөвт байгууллагуудыг холбох ажил хийгдэж байна.





**Аймгийн Орон нутгийн
хөгжлийн сангийн хөрөнгөөр
хийгдэж буй хөрөнгө оруулалт**

“Сумын төвийн хогийн цэгийн тохижилт” ДУГАНОНӨГ/202101016 гэрээний дугаартай гэрээт ажил

- Гүйцэтгэгч: “Хуримт констракшн” ХХК
- Хөрөнгө оруулалтын эх үүсвэр, төсөвт өртөг: Аймгийн ОНХСан, 70,000,000 төгрөг
- Ажлын явц: 85%
- 2021 оны 11 сарын 14-ний өдрийн байдлаар хогийг дарж булсан, далан босгож 60:40 харьцаа бүхий хог хийх талбай бэлтгэсэн, 20 тн контейнер, хог пресслэх машин нийлүүлэгдсэн зэрэг ажил хийгдсэн байна. Хог хийх талбайг хашаажуулах, хогийн чиглэлийг заасан самбар байршуулах, прессний машиныг ажилуулах 380 кВа-ийн тог татах ажлууд хийгдээгүй байна.









Сайхан-Овоо сумын ЗДТГ-ын дээврийн засвар

- Гүйцэтгэгч: М.Мөнхбаатар ахлагчтай иргэдийн бүлэг
- Хөрөнгө оруулалтын эх үүсвэр, төсөвт өртөг: Аймгийн ОНХСан, 10,000,000 төгрөг
- Ажлын явц: Ажил эхлээгүй
- 2021 оны 11 сарын 6-ний өдөр гэрээ байгуулсан хөрөнгө мөнгө орж ирээгүй байгаа учир материал татах ажил хийгдээгүй байна.



**Сумын ОНХС-ын хөрөнгөөр
2021 онд хийгдсэн төсөл
хөтөлбөр арга хэмжээнүүд**

Сумын төвийн айл өрхүүдийг хог ангилан ялгах хогийн савтай болгох ажил

- Гүйцэтгэгч: “Арцат алтай констракшн” ХХК
- Хөрөнгө оруулалтын эх үүсвэр, төсөвт өртөг: Сумын ОНХСан, 31,915,300 төгрөг
- Гэрээний дүн: 29,325,000 төгрөг
- Ажлын явц: 85%
- 2021 оны 11 сарын 14-ний өдрийн байдлаар Хог ангилан ялгах 3 өнгийн сав поошиг 282 ширхэг буюу 90 өрхөд тараагдаад байна. Үлдсэн өрхийн поошиг хил хаасантай холбоотойгоор удааширч 11 сард багтаан нийлүүлэгдэж гэрээт ажил дуусхаар байна.





Хүүхдийн цэцэрлэгийн гадна хашааг шинэчлэх

- Гүйцэтгэгч: Б.Хулан ахлагчтай иргэдийн бүлэг
- Төсөв зохиогч байгууллага: “Хүүхдийн цэцэрлэг”
- Хөрөнгө оруулалтын эх үүсвэр, төсөвт өртөг:
Сумын ОНХСан, 13,252,000 төгрөг
- Хийгдсэн ажил: 166м урттай квадрат хашаа хисэн
- Ажлын явц: 100%





Сумын ЕБС-ийн дотуур байранд “Хүүхэд хөгжлийн танхим” байгуулах

- Гүйцэтгэгч: Төгрөг багийн иргэн Х.Лувсанжамц
- Төсөв зохиогч байгууллага: “ЕБСургууль”
- Хөрөнгө оруулалтын эх үүсвэр, төсөвт өртөг: Сумын ОНХСан, 9,670,000 төгрөг
- Ажлын явц: 100%



Сумын төвийн энгийн уурхайн ундны усны эх үүсвэрт Смарт төхөөрөмж суурилуулах

- Гүйцэтгэгч: “Тэлмэн Нетворк” ХХК
- Төсөл зохиогч байгууллага: “ЗДТГазар”
- Хөрөнгө оруулалтын эх үүсвэр, төсөвт өртөг: Сумын ОНХСан, 13,000,000 төгрөг
- Гэрээний дүн: 12,970,000 төгрөг
- Гүйцэтгэл: 100%

ХУДГИЙН ӨМНӨХ ЗУРАГ



Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын төвийн Ундны усны энгийн уурхайн худагт смарт төхөөрөмж суурилуулах ажлын хүрээнд суурилуулагдсан төхөөрөмжийн зураг



Автохудаг3.0 сервер болон Terminal цэсгэй

(NFC RFID уншигчтай, LCD дэлгэцтэй)

Цахилгаан хаалт



Гэр интернет

Импульсэн тоолуур

Удирдлагын товчлуур 2 үйлдэлт



Хяналтын камер гадна, Гадна гэрэлтүүлэг

NVR, Hard disk

Вакум насос



Дотор камер

Карт 300ш

Халаагуур



Худгын барилгын 10 хоосоор хана, таацыг дулаалан, хавтан барьж ирүлдэв.



Худагт шинээр хаалга хийв,



Ус авах талбай цутгав.



Вакум цонх шинээр суурилуулав.

Сумын Ерөнхий төлөвлөгөө хийлгэх

2018 оны гэрээт ажлын дуусгалт

- Гүйцэтгэгч: Арт констракшн ХХК
- Хөрөнгийн эх үүсвэр, Төсөвт өртөг: Сумын ОНХСан 55,000,000 төгрөг
- Гүйцэтгэл :25% /Судалгааны шатанд явж байна/